



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/08

Цагаан-Уул сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. Хаагдсан зам давааны цас түрэх, малчдын хашааны цас гаргах, сэг зэм устгал ариутгалын ажилд 21.000.000 (Хорин нэгэн сая) төгрөг, ковш тракторын засварт 1.085.000 (Нэг сая наян таван мянган) төгрөг, Урсгал засварт 946.500 (Есөн зуун дөчин зургаан мянга таван зуун) төгрөг, Хамтарсан багийн зардалд 1.000.000 (Нэг сая) төгрөг, Засаг даргын Тамгын газрын тэтгэмж урамшуулалд 1.000.000 (Нэг сая) төгрөг нийт 25.031.500 (Хорин таван сая гучин нэгэн мянга таван зуун) төгрөгийг зарцуулсугай.

2. Хаагдсан зам давааны цас түрэх, малчдын хашааны цас гаргах, сэг зэм устгалын зардлыг Улаантайгын Улсын тусгай хамгаалалттай газраас шилжиж ирсэн орлогоос, Ковш тракторын засвар болон Засаг даргын Тамгын газрын урсгал зардал 2.031.500 төгрөгийг спорт заалны орлого, хайсан хашаа борлуулсны орлого 150.000, "Уу жалга" ХХК-ны тооцооны 29.500, хандивын 440.000 төгрөгийн орлогоос, Хамтарсан багийн 1.000.000 төгрөгийг 2023 оны ажлын үзүүлэлтээр шагнуулсан 1.000.000 төгрөгийн орлогоос, нэг удаагийн тэтгэмж урамшууллын 1.000.000 төгрөгийг Засаг даргын Тамгын газарт Аймгийн Засаг даргаас шагнасан 1.000.000 төгрөгийн орлогоос тус тус гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Оюунчимэг)-т зөвшөөрсүгэй.

3. Нягтлан бодох бүртгэлийн хууль, журмын дагуу санхүүгийн баримтыг бүрдүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нярав (Н.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ТҮМЭНБАЯР



Tushaal /2024/